



Сургуулийн

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/88

Нарийнтээл сум

Г Өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай Г
холбогдуулан авах зарим
арга хэмжээний тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 11.3 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Дайчилгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 19 дугаар зүйлийн 19.1, 19.1.1, 19.1.3, 19.1.4 дэхь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид болон нийт иргэдэд гамшиг ослоос урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангуулан, мэдээлэл хүргэж ажиллахыг Сумын онцгой комиссын аюулгүй байдал хариуцсан ажилтан (С.Баасандулам), байгууллагын захирал, эрхлэгч нар, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

2.Байгууллагуудын халаалтын хэвийн байдлыг хангах зорилгоор аваарын дизелийг асааж уурын зуухыг цахилгаанд холбох, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургуулийн цахилгааны асуудлыг аваарын дизелиэр, Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, Засаг даргын Тамгын газрын цахилгааны асуудлыг Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХХК-ны аваарын дизелиүдээр, бусад байгууллагуудын цахилгааны асуудлыг бага оврын цахилгааны эх үүсгэвэрүүдээр шийдвэрлэж ажиллахыг Сумын онцгой комиссын орлогч дарга (Б.Ичинноров), Байгууллагын дарга эрхлэгч нар, Эх нутгийн буян ХХК-ны менежер (Д.Ренчинлхагва) нарт үүрэг болгосугай.

3.Сумын төвийн халаалтын уурын зуухны нөөцийг нэмэгдүүлж хэвийн ажиллагааг хангаж ажиллахыг Эх нутгийн буян ХХК-ны менежер (Д.Ренчинлхагва)-д үүрэг болгосугай.

4.Өвөрхангай аймгаас Дундговь аймаг руу эрэн хайх аврах ажиллагааны дайчилгаанд сумын цагдаагийн хэсгээс 2 олон нийтийн цагдаа, Эрүүл мэндийн төвөөс эмнэлгийн яаралтай тусламжийн 4 хүний бүрэлдэхүүнтэй багийг аюулгүй байдлыг ханган томилж ажиллууахыг цагдаагийн хэсгийн төлөөлөгч

(Н.Түмэнжаргал), Эрүүл мэндийн төвийн дарга (Б.Бат-Эрдэнэ) нарт үүрэг болгосугай.

5. Аваарын дизель, цахилгааны эх үүсгэвэрүүд ажиллуулахтай холбогдон нэг хоногт гарах зардлыг тооцон сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэж ажиллахыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Пүрэвдулам), Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Пүрэвдавга) нарт зөвшөөрсүгэй.

6.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Сумын онцгой комиссын орлогч дарга (Б.Ичинноров), цагдаагийн хэсгийн төлөөлөгч (Н.Түмэнжаргал) нарт даалгасугай.

ДАРГА



Б.СУГАР



Сургуулийн

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/89

Нарийнтээл сум

Г Өндөржүүлсэн бэлэн байдал зарласантай
холбогдуулан авах зарим
арга хэмжээний тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 11.3 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, Дайчилгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 19 дугаар зүйлийн 19.1, 19.1.1, 19.1.3, 19.1.4 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөрхангай аймгийн Арвайхээрээс зүүн тийш 25км зайд 5.6 магнитудын газар хөдөлж байшин барилга нурж аюулд өртсөн учир дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсүгэй.

2.Ерөнхий зориулалттай мэргэжлийн ангийн анхны тусламжаас 2 хүн, аврах бүлгээс 5 хүн, механикжуулсан бүлгээс 1 хүн, хэв журам сахиулах бүлгээс 1 хүн бүгд 9 хүний бүрэлдэхүүнтэй багийг аюулгүй байдлыг ханган томилгоожуулах, ажиллагаанд шаардлагатай Ковш-1ш, Маяти ачааны машин-1ш, Land-80 суудлын авто машин-1ш, явуулын пост-1ш зэрэг техник хэрэгслүүдийг тус тус хариуцан дайчилгаанд ашиглахыг Онцгой комиссын гишүүн (Г.Наранбаатар), Хэв журам сахиулах мэргэжлийн ангийн дарга (Л.Батнаран) нарт үүрэг болгосугай.

3.Түлш шатахуун, хоол хүнсний зардал 3 хоногийн нөөцийг тооцоолон сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс шийдвэрлэж ажиллахыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Пүрэвдулам), Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Г.Пүрэвдавга) нарт зөвшөөрсүгэй.

4.Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид болон нийт иргэдэд гамшиг ослоос урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангуулан, мэдээлэл хүргэж ажиллахыг Сумын онцгой комиссын аюулгүй байдал хариуцсан ажилтан (С.Баасандулам), байгууллагын захирал, эрхлэгч нар, багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Сумын онцгой комиссын орлогч дарга (Б.Ичинноров), цагдаагийн хэсгийн төлөөлөгч (Н.Түмэнжаргал) нарт даалгасугай.

ДАРГА



Б.СУГАР

622311187



Сургуулийн

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/90

Нарийнтээл сум

Г Хорио цээрийн дэглэм тогтоох тухай Г

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ийн "а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 32 дугаар зүйлийн 32.1.8, 32.1.9, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.2.1, 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2, Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 266 дугаар тогтоол "Хорио цээр хягаарлалтын дэглэмийн үед хэрэгжүүлэх үйл ажиллагааны журам"-ын 3, 5, 6 дахь заалт, Улсын Мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн 2023 оны 04 дүгээр сарын 02-ний өдрийн 10475 дугаартай шинжилгээний хариуг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Шарга багийн Жонш гэх газарт малын гоц халдварт шүлхий өвчний голомт үүссэн тул 10 км радиуст голомтын бүс тогтоож 2023 оны 04 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн 14 хоногийн хугацаатай хорио цээрийн дэглэм тогтоосугай.

2. Голомтын бүсэд ажиллах мэргэжлийн багийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

3. Хорио цээрийн бүсэд хийгдэх халдваргүйтгэл, дархлаажуулалтыг чанартай зохион байгуулахыг Мал эмнэлэгийн тасгийн дарга (Д.Бямбадолгор), эмнэлэгийн үйлчилгээний нэгжийн эмч нарт, шаардлагатай мал сүргийг вакцинжуулалтанд бүрэн хамруулахыг Шарга багийн Засаг дарга (О.Цэрэннадмид)-д үүрэг болгосугай.

4. Малын гоц халдварт шүлхий өвчин тархахаас хамгаалж хорио цээрийн дэглэм сахиулах, голомтын бүсэд ажиллах хяналтын постод техник хэрэгсэл, хүн хүчийг дайчлан гаргаж, холбогдох хууль, журмыг мөрдүүлэх, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга (Н.Сайнбилэг), арга хэмжээнд шаардагдах зардлыг тооцож ажиллахыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Пүрэвдулам)-д тус тус даалгасугай.

5. Голомтын бүсэд томилогдон ажиллаж байгаа гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн албан хаагчид, голомтын бүсэд байгаа иргэдэд эрүүл мэндийн

тусламж үйлчилгээ үзүүлэх, өвчтөнийг хяналтанд авах, шаардлагатай эм тарианы нөөцийг бүрдүүлэх, эрсдэлтэй бүлгийн судалгааг гаргаж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн эрхлэгч, их эмч (Б.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

6.Хорио цээрийн бүсийн хүн амын хөдөлгөөнд хяналт тавьж хэв журам сахиулж ажиллахыг сумын хэсгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах (Н.Түмэнжаргал)-д үүрэг болгосугай.

7.Голомтын бүсэд малын шилжилт хөдөлгөөн, нүүдэл хийх, голомтын бүсээс мал малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн гаргахыг түр хугацаагаар зогсоож, хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлэгийн улсын байцаагч (Д.Бямбадолгор)-д үүрэг болгосугай.


8.Малчид, иргэд, олон нийтэд шүлхий өвчний талаарх мэдээллийг хүргэж урьдчилан сэргийлэх зөвлөмж, гарын авлага, цахим мэдээллээр хангаж ажиллахыг тархвар зүйч (П.Төмөртоогоо), багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР


Нарийнтээл сумын Засаг даргын 2023
оны 06 дугаар сарын 08 ны өдрийн 190
дугаар захирамжийн хавсралт



МАЛЫН ГОЦ ХАЛДВАРТ ШҮЛХИЙ ӨВЧНИЙ ХЯНАЛТЫН
ПОСТОНД ГАРАХ ЖИЖҮҮРИЙН ХУВААРЬ

Хоног	Албан тушаалтны нэр	Эргүүл хийх газар	Утасны дугаар
04 дүгээр сарын 02			
3 хоног	О.Цэрэннадмид	Жонш	88801906
	П.Төмөртогоо		90888870
	Ж.Батбаяр		
04 дүгээр сарын 05			
3 хоног	Э.Мөнхбат	Жонш	88823285
	Ж.Цэрэннадмид		89600406
	Т.Гантөмөр		
04 дүгээр сарын 08			
3 хоног	Г.Наранхүү	Жонш	80933434
	Б.Батдаваа		80421121
	Ж.Шижирбаатар		
04 дүгээр сарын 11			
3 хоног	Д.Наранбаатар	Жонш	80265059
	Б.Шинэбаатар		88007653
	А.Пүрэвдавга		
04 дүгээр сарын 14			
3 хоног	О.Энхжаргал	Жонш	89558615
	О.Цэрэннадмид		95092315
	А.Энхбаатар		
04 дүгээр сарын 17			
3 хоног	Ц.Ганбаатар	Жонш	88776201
	Б.Төмөрбаатар		89910933
	Б.Гантогтох		
04 дүгээр сарын 20			
3 хоног	Ц.Дэлэгням	Жонш	89950645
	Г.Мөнх-Эрдэнэ		88008162
	М.Пүрэвтогоо		

Нарийнтээл сумын Засаг даргын 2023
оны 06 дугаар сарын 08 ны өдрийн А/90
дугаар захирамжийн хавсралт



МАЛЫН ГОЦ ХАЛДВАРТ ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ

Ажлын хэсгийн ахлагч: Д.Бямбадолгор (Мал эмнэлгийн тасгийн дарга)

Гишүүдэд: П.Төмөртоогоо (Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч)

Д.Цэцгээ (Малын их эмч)

Р.Бат-Эрдэнэ (Малын их эмч)

Г.Батсүх (Малын их эмч)

Ц.Санжид (Малын их эмч)

А.Уранбаатар (Мал эмнэлэг хорио цээрийн Хяналтын цэгийн
Ариутгагч)

О.Цэрэннадмид (Шарга багийн Засаг дарга)

А.Батмөнх (жолооч)



Сургуулийн

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/91

Нарийнтээл сум

Коронавирус /Ковид-19/ цар тахлын тархалттай
Холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "б", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.7, 32 дугаар зүйлийн 32.1.1., 32.1.3, 32.1.8, 32.1.9 дэх заалт, Улсын Онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар заалт, аймгийн Онцгой комиссын 2021 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 17 дугаар хурлын тэмдэглэл, аймгийн Засаг даргын 2021 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн "Коронавируст халдвар (Ковид-19/-ын цар тахлын тархалттай холбогдуулан авах арга хэмжээний тухай" А/147 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нарийнтээл сумын Шарга багт 2023 оны 04 дүгээр сарын 02-ны өдрийн 06:00 цагт "Коронавируст халдвар (Ковид-19/-ын батлагдсан нэг тохиолдол гарсан тул, тархвар судалгааны асуумжаар Хаан банк, Хүнсний дэлгүүр, Захиргааны байгууллагын ажилчид ойрын хавьтал болсон тул Коронавирус /Ковид-19 шинжилгээг авч хариу гартал үйл ажиллагааг зогсоосугай.

2."Коронавируст халдвар (Ковид-19) цар тахлын үед хэрэглэгдэх түргэвчилсэн оношлуур, эм, эмнэлэгийн хэрэгслийн шаардлагатай нөөцийг бүрдүүлж ажиллахыг Эрүүл мэндийн төвийн эрхлэгч (Б.Бат-Эрдэнэ), Шарга багийн эмч (Д.Отгон), санхүү албаны дарга (П.Сольтогтох) нарт үүрэг болгосугай.

12.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Онцгой комиссын орлогч дарга (Б.Ичинноров), цагдаагийн хэсгийн төлөөлөгч (Н.Түмэнжаргал), Шарга багийн Засаг дарга (О.Цэрэннадмид) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б. СУГАР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 09 өдөр

Дугаар А/92

Нарийнтээл сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1, 19.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд зохион байгуулах спортын арга хэмжээ болон гар зургийн уралдааны зардалд 300.000 төгрөг зарцуулж, тооцоог хавсралтаар баталсугай.


2.Дээрх зардалд зарцуулах 300.000 төгрөгийн зардлыг сумын нэмэлт санхүүжилтын данснаас гаргахыг нягтлан бодогчийг түр орлон гүйцэтгэгч (О.Пүрэвдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

Нарийнтээл сумын Заасаг даргын 2023
оны 06 дугаар сарын 09 ны өдрийн А/92
дугаар захирамжийн хавсралт



ШАГНАЛЫН ЗАРДЛЫН ТООЦОО

№	Шагналт байр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /мян.төг/	Бүгд үнэ /мян.төг/
100 буудалт даам /эрэгтэй/					
1	1-р байр	Ш	1	30000	30000
2	2-р байр	Ш	1	25000	25000
3	3-р байр	Ш	1	20000	20000
	Дүн			75000	75000
Шатар /эрэгтэй/					
4	1-р байр	Ш	1	30000	30000
5	2-р байр	Ш	1	25000	25000
6	3-р байр	Ш	1	20000	20000
	Дүн			75000	75000
Шагай няслах, шүүрэх					
7	1-р байр	Ш	1	30000	30000
8	2-р байр	Ш	1	25000	25000
9	3-р байр	Ш	1	20000	20000
	Дүн			75000	75000
Гар зургийн уралдаан					
10	1-р байр	Ш	1	25000	25000
11	2-р байр	Ш	1	20000	20000
12	3-р байр	Ш	1	15000	15000
13	4-р байр	ш	1	15000	15000
	дүн			75000	75000

_____оо_____



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 15 өдөр

Дугаар А/93

Нарийнтээл сум

Мал, амьтны гоц халдварт бог малын мялзан өвчнөөс
урьдчилан сэргийлэх яаралтай вакцинжуулалтийг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дүгээр зүйлийн 60.1.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, дахь заалт, аймгийн Засаг даргын 2023 оны "Мал, амьтны гоц халдварт бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах тухай" А/370 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Мал, амьтны гоц халдварт бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтыг 2023 оны 06 дугаар сарын 16-ний өдрөөс 06 дүгээр сарын 30-ны өдрийн дотор зохион байгуулахыг "Бумбат суврага", "Бумбат-Ур" мал эмнэлэг үйлчилгээний нэгжүүдэд үүрэг болгосугай.
2. Мал, амьтны гоц халдварт Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.
3. Бог малын мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины дархлаа тогтох хүртэлх хугацаанд малчдын нүүдэл, малын шилжилт хөдөлгөөн хийхгүй байх, дархлаажуулалтын товыг мал бүхий иргэд, малчин нарт зарлан мэдээлж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.
4. Ишиг, хурганд хийх мал, амьтны гоц халдварт "Бог малын мялзан" өвчний дархлаажуулалтын ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж, үр дүнд хяналт тавьж, холбогдох газарт тайлагнаж ажиллахыг мал эмнэлгийн улсын байцаагч (Д.Бямбадолгор)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.СУГАР



Нарийнтээл сумын Засаг даргын 2023
оны 06 дугаар сарын 15 ны өдрийн А/93
дугаар захирамжийн хавсралт



**МАЛЫН ГОЦ ХАЛДВАРТ БОГ МАЛЫН МЯЛЗАН ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН
СЭРГИЙЛЭХ ДАРХЛААЖУУЛАЛТЫН АЖЛЫН ХЭСЭГ**

Ажлын хэсгийн ахлагч: Д.Бямбадолгор (Мал эмнэлгийн тасгийн дарга)

Гишүүдэд: П.Төмөртоогоо (Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч)

Г.Батсүх (Малын их эмч)

Д.Цэцгээ (Малын их эмч)

Р.Бат-Эрдэнэ (Малын их эмч)

Ц.Санжид (Малын их эмч)

О.Цэрэннадмид 1 дүгээр багийн Засаг дарга

Б.Базарсад 2 дугаар багийн Засаг дарга

О.Мягмар (3 дугаар багийн Засаг дарга)

Ц.Мөнх-Эрдэнэ 4 дүгээр багийн Засаг дарга

О.Энх-Амгалан (жолооч)

_____о0о_____



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 19 өдөр

Дугаар А/94

Нарийнтээл сум

Тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын иргэн Н.Өлзийтогтохын ээж өвчний улмаас нас барсан тул 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн тусламж үзүүлсүгэй.


2.Дээрх 100,000 төгрөгийн зардлыг Засаг даргын нөөц сангаас гаргахыг төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Пүрэвдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

Нарийнтээл сумын Засаг даргын 2023
оны 06 дугаар сарын 22-ны өдрийн А/96
дугаар захирамжийн хавсралт



ЗАРДЛЫН ТООЦОО

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /мян.төг/	Бүгд үнэ /мян.төг/
1	Дурсгалын зүйл	ш	6	80.000	480.000
Дүн					480.000

_____ооо_____



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/97

Нарийнтээл сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 124 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Баянтээг багт Хөв цөөрөм байгуулах" ажилд хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Базарсад (Баянтээг багийн Засаг дарга)

Гишүүд: Г.Наранбаатар (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Л.Батнаран (Экологийн асуудал хариуцсан байцаагч)

Ц.Цэвээнсүрэн (Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны
мэргэжилтэн)

Д.Бадамцэцэг (Сумын Иргэдийн хурлын Төлөөлөгч)

О.Баттөмөрцоож (Малчин)

Н.Хүдэрбат (Малчин)

Т.Энхбаатар (Малчин)

Ж.Дамдинсүрэн (Малчин)

Л.Лхагвасүрэн (Малчин)

2. "Хөв цөөрөм байгуулах" ажлыг зураг төслийн дагуу хийж буй эсэхэд хяналт тавьж, ажлын тайланг сумын Засаг даргын зөвлөлд танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Базарсад)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 28 өдөр

Дугаар А/98

Нарийнтээл сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1 дэхь заалт, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын чанартай АО302 авто замаас Баянтээг ХК хүртэлх 22 километр нүүрс тээвэрлэх замыг цэгцлэх, хяналт тавьж ажиллах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Базарсад (Баянтээг багийн Засаг дарга)

Гишүүд: Ч.Ганхуяг (Баянтээг ХК-ны захирал)

Н.Түмэнжаргал (Хэсгийн төлөөлөгч)

Л.Батнаран (Экологийн асуудал хариуцсан байцаагч)

Г.Наранбаатар (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

Д.Бадамцэцэг (Сумын Иргэдийн хурлын Төлөөлөгч)

Б.Ган-Өлзий (Баянтээг багийн Нийгмийн ажилтан)

Б.Баярсайхан (Байгаль орчны ажилтан)

Г.Тайванжаргал (Малчин)

Т.Энхбаатар (Малчин)

Ж.Дамдинсүрэн (Малчин)

О.Баттөмөрцоож (Малчин)

2. Нүүрс тээвэрлэх замыг цэгцлэн зөвхөн тэмдэглэсэн нэг замаар явуулах ажлыг зохион байгуулж, ажлын тайланг сумын Засаг даргын зөвлөлд танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Базарсад)-д үүрэг болгосугай.

3. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах зардлыг шийдвэрлэж ажиллахыг Баянтээг ХК-ны захирал Ч.Ганхуяг зөвлөсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.СУГАР





ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
НАРИЙНТЭЭЛ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 30 өдөр

Дугаар А/99

Нарийнтээл сум

Салбар хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэхь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023 оны сумын Үндэсний баяр наадам, сум байгуулагдсаны түүхт 92 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах салбар хороодыг хавсралтаар баталсугай.

2.Сумын Үндэсний баяр наадам, сум байгуулагдсаны түүхт 92 жилийн ойг зохион байгуулалт сайтай явуулж сумын Засаг даргын зөвлөлд тайлагнахыг салбар хороодын дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.СУГАР

Нарийнтээл сумын Засаг даргын 2023
оны ... дугаар сарын ... ны өдрийн ...
дүгээр захирамжийн хавсралт

СУМЫН БАЯР НААДМЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
САЛБАР ХОРООДЫН БҮРЭЛДЭХҮҮН

1. Хурдан морины салбар хороо:
Салбар хорооны дарга: Г.Батсүх (Засаг даргын орлогч)
Гишүүд: 1. С.Баасандулам (ЗДТГ-ын хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн)
2. Б.Шинэбаатар (Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн)
3. П.Төмөртоогоо (Мал эмнэлгийн тасгийн тархвар зүйч)
4. С.Пүрэвсүрэн (МЭХЦХЦ-ийн дарга)
5. Б.Бат-Эрдэнэ (Эрүүл Мэндийн төвийн их эмч)
6. Б.Ганбаатар (Эмнэлгийн жолооч)
7. Ц.Сайнбилэг (ЗДТГ-ын нийгмийн бодлогын мэргэжилтэн)
8. Б.Мөнгөнтуяа (Даатгалын байгууллагын төлөөлөл)
9. С.Мөнхдэлгэр (Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтан)
10. Ц.Мөнх-Эрдэнэ (4 дүгээр багийн Засаг дарга)
11. О.Энх-Амгалан (ИТХ-ын жолооч)
12. Ц.Гантулга (Хогны машины жолооч)
13. Г.Амарбаясгалан (Дүйцүүлэхийн цэрэг)
14. Э.Дөлгөөн (Дүйцүүлэхийн цэрэг)
15. Баттөмөр (Дүйцүүлэхийн цэрэг)
2. Бөхийн салбар хороо:
Салбар хорооны дарга: Б.Бат-Эрдэнэ (МЭХЦХЦ-ийн малын их эмч)
Гишүүд: 1. О.Мягмар (3 дугаар багийн Засаг дарга)
2. Ц.Нямцогт (иргэн)
3. А.Отгонбаяр (ЕБС-ийн бөхийн дасгалжуулагч)
4. С.Цогтбаатар (бөхийн холбооны тэргүүлэгч)
5. О.Цэрэннадмид (1 дүгээр багийн Засаг дарга)
6. А.Батмөнх (ЗДТГ-ын жолооч)
7. М.Мөнхбаатар (Иргэн)
3. Сурын харвааны салбар хороо:
Салбар хорооны дарга: Н.Сайнбилэг (ИТХ-ын нарийн бичгийн дарга)
Гишүүд: 1. Ц.Цэвээнсүрэн (Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны мэргэжилтэн)
2. Т.Золжаргал (Ерөнхий боловсролын нягтлан бодогч)
4. Шагайн харвааны салбар хороо:
Салбар хорооны дарга: Д.Энхбаатар (ЕБС-ийн багш)
Гишүүд: С.Сангижаргал (Шагайн холбооны)
О.Энхтайван (ЕБС-ийн багш)

5. Хэв журам сахиулах салбар хороо:

Салбар хорооны дарга: Б.Ичинноров (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: 1.Н.Түмэнжаргал (Хэсгийн төлөөлөгч)

2. Л.Батнаран (Экологийн асуудал хариуцсан байцаагч)

3.Д.Дашзэвгэ (Нийтийн хэв журам хамгаалах тасгийн эргүүлийн цагдаа)

4. Б.Чимэд-Очир (Олон нийтийн цагдаа)

5. Г.Мөнх-Эрдэнэ (Зохицуулагч)

6. Г. Наранбаатар (Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

6.Аж ахуйн салбар хороо:

Салбар хорооны дарга:П.Сольтогтох (Төсөв төрийн сангийн мэргэжилтэн)

Гишүүд:1.О.Пүрэвдулам (Төсвийн ерөнхий нягтлан бодогч)

2.Д.Бямбадолгор (Мал эмнэлгийн тасгийн дарга)

3.Э.Мөнхбат (Тамгын газрын нярав)

4.Д.Энхжин(Газар тариалан хариуцсан мэргэжилтэн)

5. Ч.Оюунзул (Архив, бичиг хэргийн ажилтан)

6. Б.Ган-Өлзий (Баянтээг багийн Нийгмийн ажилтан)

7.Н.Нямсүрэн (Нийгмийн даатгалын ажилтан)

8.Ц.Дэлэгням (Усны харуул)

9. Т.Батцэцэг (Үйлчлэгч)

10.Н.Цэнд-Аюуш (ЗДТГ-ын гэрээт ажилтан)

8. Соёл урлагийн салбар хороо:

Салбар хорооны дарга:М.Ганжаргал (Соёлын төвийн эрхлэгч)

1.Ч.Цэцэгжаргал (Номын санч)

2. Д.Наранбаатар (Соёлын төвийн нярав)

3. Ж.Цэрэннадмид (Орон нутаг судлах танхимын Ажилтан)

4.Л.Загармаа (Соёлын төвийн үйлчлэгч)